

## АГУУЛГА

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Нэгдүгээр зүйл. Байгууллагын нэр, байршил .....	3
Хоёрдугаар зүйл. Үйл ажиллагааны үндсэн зарчим.....	3
Гуравдугаар зүйл. МҮОХ-ны зорилго .....	4
Дөрөвдүгээр зүйл. МҮОХ-ны эрх, үүрэг .....	6

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ МҮОХ-НЫ ГИШҮҮНЧЛЭЛ**

Тавдугаар зүйл. Гишүүнчлэл.....	8
Зургаадугаар зүйл. Гишүүнчлэлийн шалгуур.....	8
Долоодугаар зүйл. Гишүүнчлэлийн хүсэлт .....	10
Наймдугаар зүйл. Гишүүдийн эрх, үүрэг .....	10
Есдүгээр зүйл. Гишүүнчлэл дуусгавар болох.....	11
Аравдугаар зүйл. Арга хэмжээ болон шийтгэл.....	11
Арван нэгдүгээр зүйл. Гишүүний бүртгэл.....	12

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ МҮОХ-НЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БҮРЭЛДЭХҮҮН**

Арван хоёрдугаар зүйл. МҮОХ-ны удирдлагын тогтолцоо .....	13
Арван гуравдугаар зүйл. МҮОХ-ны Чуулганы бүрэлдэхүүн ба санал өгөх эрх .....	13
Арван дөрөвдүгээр зүйл. МҮОХ-ны Чуулган .....	14
Арван тавдугаар зүйл. МҮОХ-ны Гишүүдийн хурал.....	17
Арван зургаадугаар зүйл. МҮОХ-ны Чуулган ба Гишүүдийн хурлыг зарлах, хуралдуулах үндсэн баримтлал.....	19
Арван долоодугаар зүйл. МҮОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл.....	21
Арван наймдугаар зүйл. МҮОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл дэх сул орон тоо .....	23
Арван есдүгээр зүйл. МҮОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн эрх, үүрэг .....	23
Хорьдугаар зүйл. Гүйцэтгэх зөвлөлийн хурал.....	24

Хорин нэгдүгээр зүйл. Ерөнхийлөгч .....	26
Хорин хоёрдугаар зүйл. Ерөнхий нарийн бичгийн дарга .....	27
Хорин гуравдугаар зүйл. Хянан шалгах зөвлөл .....	28
Хорин дөрөвдүгээр зүйл. Комисс ба ажлын хэсгүүд .....	29
Хорин тавдугаар зүйл. МҮОХ-ны Тамирчдын Комисс .....	29
Хорин зургаадугаар зүйл. Төр, засгийн байгууллагатай харилцах .	30
Хорин долоодугаар зүйл. МҮОХ-ны Олимпын зөвлөл.....	30

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ  
ХӨРӨНГӨ, САНХҮҮ**

Хорин наймдугаар зүйл. МҮОХ-ны хөрөнгө, санхүү .....	31
--	----

**ТАВДУГААР БҮЛЭГ  
МҮОХ-НЫ БЭЛГЭДЭЛ**

Хорин есдүгээр зүйл. Бэлгэдэл .....	33
-------------------------------------	----

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ  
МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

Гучдугаар зүйл. Маргаан шийдвэрлэх .....	34
--	----

**ДОЛООДУГААР БҮЛЭГ  
БУСАД ЗҮЙЛ**

Гучин нэгдүгээр зүйл. Татан буулгах.....	35
Гучин хоёрдугаар зүйл. МҮОХ-ны дүрэмд өөрчлөлт оруулах болон Олимпын Хартийг баримтлах.....	35

Хавсралт 1 МҮОХ-ны Тамирчдын комиссын удирдамж .....	36
---	----

Хавсралт 2 Сонгууль явуулах журам.....	38
---	----

Хавсралт 3 МҮОХ -ны бэлгэдэл.....	40
--------------------------------------	----

## **МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛИМПЫН ХОРООНЫ ДҮРЭМ**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

### **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **Нэгдүгээр зүйл. Байгууллагын нэр, байршил**

- 1.1. Байгууллагын нэр нь монгол хэлээр Монголын Үндэсний Олимпын Хороо (цаашид “МҮОХ” гэж товчилно), англи хэлээр Mongolian National Olympic Committee байна
- 1.2. Байршил: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Монголын Үндэсний Олимпын хороо
- 1.3. Байгуулагдсан он, сар, өдөр: 1956 оны 2 дугаар сарын 26-ны өдөр

#### **Хоёрдугаар зүйл. Үйл ажиллагааны үндсэн зарчим**

- 2.1. МҮОХ нь Олимпын Хартийг удирдлага болгож, Монгол Улс дахь Олимпын хөдөлгөөнийг хөгжүүлэх зорилго бүхий ашгийн төлөө бус, үйл ажиллагаа нь хязгааргүй, хууль ёсоор улсын бүртгэлд бүртгэгдсэн төрийн бус байгууллага, хуулийн этгээд мөн. Энэхүү байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулна. Олимпын хөдөлгөөний байгууллага болох МҮОХ нь Олимпын Харт, Олон Улсын Олимпын Хорооны шийдвэр, Дэлхийн допингийн эсрэг Дүрмийг хүндэтгэн сахиж ажиллана. Хуулийн этгээдийн хувьд спортын үйл ажиллагаан дахь хүйсийн тэгш байдлыг ханган ажиллана. Мөн спортын ёс зүйг сахиж, допингтой тэмцэх болон хүрээлэн буй орчны асуудлуудад хариуцлагатай хандана.

- 2.2. МҮОХ нь Олимпын Харти болон Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, бусад хууль тогтоомжийг хүндэтгэн сахиж, төр, засгийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэдтэй дүрмийнхээ хүрээнд хамтран ажиллах бөгөөд Олимпын Хартийг зөрчсөн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй.
- 2.3. МҮОХ нь Олимпын хөдөлгөөнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт төлөөлөх онцгой эрхтэй байна.
- 2.4. МҮОХ нь Олон Улсын Олимпын Хорооны /цаашид “ОУОХ” гэж товчилно/ ивээл дор зохиогдох олимп, тив, бүс болон дэлхийн спортын наадамд Монгол Улсыг төлөөлөх онцгой эрхийг Олимпын Хартийн дагуу дангаар эдэлнэ.
- 2.5. МҮОХ нь Олимпын Хартийг дагаж мөрдөх, бүрэн бие даасан байдлаа сахин хамгаалахад саад тотгор учруулж болох аливаа хэлбэрийн дарамт шахалтыг няцаана.
- 2.6. Аливаа улс төр, хууль зүй, шашин, эдийн засгийн дарамт шахалтын эсрэг зохих арга хэмжээ авч, бие даасан байдлаа сахин хамгаална.
- 2.7. Монгол Улсад биеийн тамир, спортыг хөгжүүлэх төрийн бодлого, үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд тал бүрийн дэмжлэг үзүүлнэ.

### **Гуравдугаар зүйл. МҮОХ-ны зорилго**

- 3.1. Монгол Улсад Олимпын хөдөлгөөнийг хөгжүүлэх, хамгаалах, сурталчлан дэлгэрүүлэх;
- 3.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт Олимпын Хартийн хэрэгжилтэд хяналт тавих;
- 3.3. Үндэсний Олимпын академи, Олимпын музей, Олимпын хөдөлгөөний соёл, боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон түмэнд түгээн дэлгэрүүлэх;

- 3.4. Спортын мэргэжилтэн, удирдах ажилтныг бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд анхаарах ба биеийн тамир, спортын салбарт спортын шинжлэх ухааны ололт, амжилтыг нэвтрүүлэх;
- 3.5. Өндөр зэрэглэлийн тамирчдын амжилтыг дээшлүүлэх, нийтийн биеийн тамирыг дэмжин хөгжүүлэх;
- 3.6. Спортод ялгаварлан гадуурхах, хүчирхийлэх хэлбэрийг эсэргүүцэх ба биеийн тамир, спортын хөгжилд саад учруулах аливаа сөрөг нөлөөллийн эсрэг идэвхтэй тэмцэх;
- 3.7. Дэлхийн допингийн эсрэг дүрмийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэхийн зэрэгцээ допингийн эсрэг МҮОХ-ны бодлого, дүрэм, гишүүнчлэл, санхүүжилтийн шаардлага болон үр дүнгийн журмыг Дэлхийн допингийн эсрэг дүрэмд нийцүүлэн боловсруулж, түүнд заасан Үндэсний Олимпын Хороо (цаашид “ҮОХ” гэж товчилно)-дын үүрэг, хариуцлагыг сахин биелүүлэх;
- 3.8. ОУОХ-ны Ёс зүйн дүрэм болон спортын байгууллагуудын сайн засаглалын үндсэн зарчмыг сахих;
- 3.9. Үндэсний хэмжээнд энх тайван, спорт ба эмэгтэйчүүдийг дэмжих үйл ажиллагааг өрнүүлэх, хүрээлэн буй орчны асуудалд онцгой анхаарал хандуулах;
- 3.10. МҮОХ-ны гишүүн биеийн тамир, спортын байгууллага болон холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- 3.11. Тамирчдад эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх, хамгаалах;
- 3.12. Тэмцээн, уралдааныг будлиантуулахаас урьдчилан сэргийлэх тухай Олимпын хөдөлгөөний кодыг хэрэгжүүлэх;

## **Дөрөвдүгээр зүйл. МҮОХ-ны эрх, үүрэг**

- 4.1. Олимпын Хартийн хүрээнд Олимпын хөдөлгөөний асуудлаар санал боловсруулах;
- 4.2. Олимпын наадмыг зохион байгуулахаар нэр дэвшиж буй хотын тухай санал хүсэлтийг ОУОХ-нд хүргүүлэх;
- 4.3. Олон Улсын Олимпын Чуулган, Үндэсний Олимпын Хороодын Холбоо (АНОС)-ны ерөнхий ассамблейн бэлтгэл ажилд хамтарч оролцох;
- 4.4. ОУОХ, түүний хүлээн зөвшөөрсөн байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах, дэмжлэг туслалцаа авах;
- 4.5. Спортын холбоодын саналыг үндэслэн Олимпын наадам болон ОУОХ-ны ивээл дор зохион байгуулагдаж буй тив, бүс, дэлхийн спортын наадамд оролцох Монгол Улсын баг, тамирчдыг бүрдүүлэх, шийдвэр гаргах, зохион байгуулж оролцуулах болон багийн гишүүдийн сахилга батыг хариуцах;
- 4.6. ОУОХ-ны урилгын дагуу Олимпын наадамд оролцох Монгол Улсын баг тамирчдыг зохион байгуулж оролцуулах;
- 4.7. Олон улсын спортын болон үндэсний байгууллагуудтай Олимпын Хартийн хүрээнд хамтран ажиллах;
- 4.8. МҮОХ-ны зорилгод нийцүүлэн үйл ажиллагаа явуулж буй спортын холбоодыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
- 4.9. Олимпын Эв санааны нэгдлийн хөтөлбөрт хамрагдах ба туслалцаа авах;
- 4.10. Спортын маркетингийг хөгжүүлэх, санхүүгийн шинэ эх үүсвэр бий болгох, хандивлагч байгууллага ба иргэдтэй хамтран ажиллах;

- 4.11. Олимпын үзэл санааг дэлгэрүүлэн хөгжүүлэх, сургалт, сурталчилгааны ажлыг удирдан зохион байгуулах;
- 4.12. Олимпын наадам, тив, бүсийн спортын наадамд оролцох тамирчдын эрүүл мэндийг даатгуулан тэдний эрх ашгийг хамгаалах;
- 4.13. Олимпын хөдөлгөөнд хувь нэмэр оруулсан хувь хүн, байгууллагыг МҮОХ-ны шагналаар шагнаж урамшуулах, төр, засгийн шагналд дэвшүүлэх, МҮОХ-ны дээд шагнал “Алтан-Од” одонг Гүйцэтгэх зөвлөлийн шийдвэрээр, бусад шагналыг Ерөнхийлөгчийн шийдвэрээр олгоно.
- 4.14. Эх орондоо олимпын наадам ба тив, бүсийн спортын наадмыг зохион байгуулах тухай саналаа ОУОХ, Азийн Олимпын зөвлөл (цаашид АОЗ гэх), бүсийн холбоонд хүргүүлэх;
- 4.15. МҮОХ нь ОУОХ-ны онцгой эрхт өмч болох Олимпын бэлгэ тэмдэг, туг, уриа, сүлд дууллыг зөвхөн Олимпын хөдөлгөөнийг хөгжүүлэх ашгийн бус үйл ажиллагаанд Олимпын Хартийн дагуу ОУОХ-ны зөвшөөрөлтэйгөөр, түүний нэр төрд нь халдахгүйгээр ашиглах эрхтэй. Олимпын тэмдэг, туг, уриа, сүлд дуулал, таних тэмдэг, бэлгэдэл, галт бамбар гэх мэт Олимпын өмч болон “Олимпын наадам”, “Олимпиад” гэсэн нэр ба энэ хоёр нэрээр хязгаарлагдахгүй ашиглах онцгой эрхийг ОУОХ эзэмшинэ. МҮОХ нь Олимпын Хартийн 7-14-д хамаарах тайлбарыг ханган биелүүлнэ. МҮОХ-ны дүрмийг зөрчих болон Олимпын өмчийг зөвшөөрөлгүй ашиглахын эсрэг тууштай тэмцэх ба ОУОХ-ны их үйл хэргийн төлөө Олимпын өмчийг хамгаалахад онцгой анхаарна.
- 4.16. Нийтийн биеийн тамир, их спортыг хөгжүүлэх ба спортын нөөц, залгамж халааг бэлтгэх ажилд дэмжлэг үзүүлэх, биеийн тамир, спортын үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ба боловсруулахад оролцох;

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### МҮОХ-НЫ ГИШҮҮНЧЛЭЛ

#### Тавдугаар зүйл. Гишүүнчлэл

5.1. МҮОХ нь дараах гишүүнчлэлтэй байна:

- 5.1.1. Олимпын наадмын хөтөлбөрт багтдаг Олон улсын спортын холбоодын гишүүн үндэсний спортын холбоод буюу энэхүү дүрмийн 13.1.1 заалтын дагуу томилогдсон тэдгээрийн төлөөлөл;  
Эдгээр холбоод нь ямар ч тохиолдолд МҮОХ-ны гишүүн байх бөгөөд Олимпын Хартийн дагуу МҮОХ-ны Чуулган, Гишүүдийн хурал, Гүйцэтгэх зөвлөлд олонхыг бүрдүүлнэ.
- 5.1.2. Олимпын наадмын хөтөлбөрт багтдаггүй ОУОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн, олон улсын спортын холбооны гишүүн үндэсний спортын холбоод;
- 5.1.3. МҮОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн спортын байгууллагууд ба үндэсний спортын холбоод, МҮОХ-ны орон нутаг, дүүргүүдийн Олимпын зөвлөлүүд;
- 5.1.4. Монгол Улсын иргэн ОУОХ-ны гишүүн, ОУОХ-ны хүндэт гишүүн;
- 5.1.5. ОУОХ-ноос баталсан журмын дагуу байгуулагдсан МҮОХ-ны Тамирчдын Комиссын төлөөлөл 2 тамирчин (сүүлийн 3 Олимпын наадмын аль нэгэнд нь оролцсон байх);
- 5.1.6. МҮОХ-ны гишүүдийн хурлаас сонгогдсон Олимпын медальтнуудын төлөөлөл 2 хүн;

#### Зургаадугаар зүйл. Гишүүнчлэлийн шалгуур

6.1 МҮОХ-ны гишүүн, иргэн, байгууллага нь дараах нөхцөлийг хангасан байна:

- 6.1.1. 18 нас болон түүнээс дээш насны Монгол Улсын иргэн байх;
- 6.1.2. Спортын холбоод нь олон улсын спортын холбоодын гишүүн байх ба хуульд нийцсэн үйл ажиллагаа явуулдаг байх;



- 6.1.3. МҮОХ-ны гишүүн байгууллага нь Олимпын Харт, ОУОХ-ны Ёс зүйн дүрэм, Дэлхийн допингийн эсрэг дүрэм болон тэдгээрийн заалтуудын дагуу үйл ажиллагаа явуулдаг байх;
  - 6.1.4. Гишүүн спортын холбоод нь жил бүр улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулдаг байх;
  - 6.1.5. МҮОХ-ны Гишүүдийн хурлаас тогтоосон МҮОХ-ны гишүүнчлэлийн татварыг тухай бүрд нь төлдөг байх;
  - 6.1.6. МҮОХ-нд үйл ажиллагааны тайлангаа жил бүр гаргаж өгдөг байх;
- 6.2. МҮОХ нь Олон Улсын спортын холбооны гишүүн зөвхөн нэг спортын холбоог хүлээн зөвшөөрнө.
- 6.3. Олимпын наадмын хөтөлбөрт багтдаг болон тус хөтөлбөрт үл багтдаг спортын төрлүүдийн Монгол Улсын спортын холбоод нь МҮОХ-ны гишүүнээр хүлээн зөвшөөрөгдөхийн тулд дараах шаардлагыг хангана. Үүнд:
- А. Тухайн спортын төрлөөр бие даасан үйл ажиллагаа явуулдаг байх;
  - Б. ОУОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн Олон улсын спортын холбоонд харьяалагддаг байх;
  - В. Олимпын Харт болон Олон улсын спортын холбооны дүрэм, холбогдох заалтуудад үйл ажиллагаагаа нийцүүлэн явуулдаг байх;
- 6.4. Засгийн газар болон бусад удирдах байгууллагын шийдвэрээр МҮОХ-ны гишүүдийг томилж болохгүй.
- 6.5. ОУОХ-ны гишүүнээс хөөгдсөн хүн МҮОХ-ны гишүүн байж болохгүй.
- 6.6. Спортын захиргааны байгууллагад орон тоогоор ажиллаж буй ажилтнуудаас бусад МҮОХ-ны гишүүд нь үүргийнхээ дагуу гүйцэтгэсэн ажлынхаа төлөө ямар нэгэн цалин хөлс, урамшуулал авахгүй. Эдгээр гишүүд нь үүрэгт ажлаа гүйцэтгэхтэй холбоотой гарсан тээвэр, байр, хоол болон бусад холбогдолтой зардлууддаа нөхөн төлбөр авч болно.

## **Долоодугаар зүйл. Гишүүнчлэлийн хүсэлт**

- 7.1. Гишүүнээр элсэх хүсэлтийг МҮОХ-ны Гүйцэтгэх зөвлөлд бичгээр ирүүлнэ. Гүйцэтгэх зөвлөл тухайн хүсэлтийг хянан үзэж, МҮОХ-ны Гишүүдийн хуралд оруулж, шийдвэрлүүлнэ.
- 7.2. МҮОХ-ны гишүүнээр элсэх хүсэлт нь МҮОХ-ны дүрмийн шаардлагуудыг хангасан байх бөгөөд нэмэлт материалуудыг хавсаргасан байна.

## **Наймдугаар зүйл. Гишүүдийн эрх, үүрэг**

- 8.1. МҮОХ-ны гишүүд нь санал өгөх, сонгох, сонгогдох болон сонгуульд гишүүдийг нэр дэвшүүлэх эрхтэй байна.
- 8.2. Урилгаар оролцож буй төлөөлөгчид МҮОХ-ны Чуулган, Гишүүдийн хуралд таслах эрхгүйгээр оролцоно.
- 8.3. Гишүүд нь МҮОХ-ны үйл ажиллагааны талаар мэдээлэл авах эрхтэй бөгөөд өөрсдийн үйл ажиллагааныхаа талаар МҮОХ-нд тогтмол мэдээлэл өгөх үүрэгтэй.
- 8.4. Гишүүд нь үйл ажиллагаагаа хөгжүүлэх зорилгоор МҮОХ-ноос тусламж, дэмжлэг авах эрхтэй.
- 8.5. Гишүүд нь МҮОХ-ноос зохион байгуулж буй үйл ажиллагаа, уулзалтуудад идэвхтэй оролцох үүрэгтэй.
- 8.6. Гишүүд нь МҮОХ-ны дүрэм, Олимпын Харти болон түүний заалтуудад нийцүүлэн гаргасан бүхий л шийдвэрийг хүндэтгэн хүлээн авч, хэрэгжүүлэх үүрэгтэй.
- 8.7. Гишүүд нь Олимпын Харти, ОУОХ-ны Ёс зүйн дүрэм, МҮОХ-ны дүрэм болон тухайн холбооны дүрэм, журмуудыг сахин биелүүлнэ.
- 8.8. МҮОХ-ны гишүүн спортын холбоод нь ОУОХ-ны ивээл дор зохион байгуулагддаг бүс, тив, дэлхийн спортын наадам, ялангуяа Олимпын наадамд баг тамирчдаа бэлтгэх, сонгон

шалгаруулах үйл ажиллагаагаа явуулахдаа МҮОХ-той хамтран ажиллана.

- 8.9. Гишүүд нь аль нэгэн комисс эсвэл ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтаж, үүрэг гүйцэтгэж болно.
- 8.10. Гишүүд нь Олимпын Харти болон бусад заалтуудын дагуу эрх эдэлж, үүргээ биелүүлнэ.

### **Есдүгээр зүйл. Гишүүнчлэл дуусгавар болох**

9.1. Гишүүнчлэл нь дараах тохиолдолд дуусгавар болно:

- 9.1.1. Нас барах;
- 9.1.2. Өөрийн хүсэлтээр гишүүнчлэлээс гарах; Энэ тухай хүсэлтээ бичгээр гаргана.
- 9.1.3. Гишүүний үүргээ биелүүлээгүй тохиолдолд МҮОХ-ны Гишүүдийн хуралд оролцогчдын 2/3-оос доошгүй саналаар гишүүнчлэлээс хасах;
- 9.1.4. Хуулийн этгээд татан буугдах;
- 9.1.5. Гишүүнээс хөөгдөх (10 дугаар зүйлд дурдсаны дагуу).

### **Аравдугаар зүйл. Арга хэмжээ болон шийтгэл**

10.1. Гишүүн өөрийн хүлээсэн үүргийг хангалттай биелүүлээгүй болон Олимпын Харти, ОУОХ-ны Ёс зүйн дүрэм болон МҮОХ-ны дүрмийг зөрчсөн тохиолдолд гаргасан зөрчил, учруулсан хохирлын хэмжээнээс хамааран дараах шийтгэлийн аль нэгийг оногдуулна:

- 10.1.1. Сануулах;
- 10.1.2. Түдгэлзүүлэх;
- 10.1.3. Хөөх;

10.2. Гишүүнд сануулга өгөх арга хэмжээ оногдуулахдаа МҮОХ-ны Гүйцэтгэх зөвлөлийн хурлаас тухайн гишүүнд тайлбар өгөх боломж олгосны дараа шийдвэрийг гаргана. Гүйцэтгэх зөвлөл гаргасан шийдвэрээ МҮОХ-ны Гишүүдийн дараагийн хуралд танилцуулна.

- 10.3. Гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсвэл хөөх шийдвэрийг Гишүүдийн хурлаас тухайн гишүүнд тайлбар хийх хангалттай боломж олгосны дараагаар гаргана. Энэхүү шийдвэр нь тухайн хуралд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй саналаар хүчин төгөлдөр болно.
- 10.4. Гишүүнчлэлийн шалгуур нөхцөл (6 дугаар зүйл)-ийг хангаагүйгээс бүрэн эрхийг нь түдгэлзүүлсэн болон хөөгдсөн гишүүд нь тэдгээр нөхцөлүүдийг хангасны дараагаар МҮОХ-ны Гишүүдийн хурлын шийдвэрээр гишүүнчлэлээ сэргээж болно.

#### **Арван нэгдүгээр зүйл. Гишүүний бүртгэл**

- 11.1. Гишүүний бүртгэлийг Ерөнхий нарийн бичгийн дарга хийж, тогтмол шинэчилж байх ёстой. Энэ бүртгэлд дараах мэдээллүүд багтана. Үүнд:
- Гишүүний нэр, хаяг;
  - Гишүүнчлэлийн хугацаа (гишүүн болсон хурлын шийдвэр, хурлын тэмдэглэлийн хуулбар байна);
  - Гишүүнээр элсүүлсэн МҮОХ-ны Гишүүдийн хурлын тэмдэглэл;
  - Хаанаас сонгогдсон болон гишүүний сонгуульт ажил Энэ бүртгэл нь МҮОХ-ны ямар ч хурлын үед хэрэглэхэд нээлттэй байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### МҮОХ-НЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БҮРЭЛДЭХҮҮН

#### Арван хоёрдугаар зүйл. МҮОХ-ны удирдлагын тогтолцоо

12.1. МҮОХ-ны удирдлагын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна.

- 12.1.1. Чуулган;
- 12.1.2. Гишүүдийн хурал;
- 12.1.3. Гүйцэтгэх зөвлөл;
- 12.1.4. Ерөнхийлөгч;

12.2. МҮОХ-ны Чуулган, Гишүүдийн хурал нь МҮОХ-ны эрх барих дээд байгууллага мөн.

12.3. МҮОХ-ны гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч нь Гүйцэтгэх зөвлөл, Ерөнхийлөгч мөн.

#### Арван гуравдугаар зүйл. МҮОХ-ны Чуулганы бүрэлдэхүүн ба санал өгөх эрх

13.1. Олимпын Харти болон энэхүү дүрмийн 5.1 дүгээр зүйлд заасны дагуу МҮОХ-ны Чуулган, Гишүүдийн хурал нь дараах төлөөлөгчдөөс бүрдэнэ.

- 13.1.1. Олимпын наадмын хөтөлбөрт багтдаг спортын төрлийн олон улсын спортын холбооны гишүүн спортын холбоо бүрээс тус бүр саналын эрхтэй 3 төлөөлөгч оролцоно. Эдгээр бие төлөөлөгчийн бүрэлдэхүүнд холбооны ерөнхийлөгч орох ба үлдсэн 2 төлөөлөгчийг холбооны Удирдах зөвлөлийн гишүүдээс сонгоно. Холбооны ерөнхийлөгч оролцох боломжгүй тохиолдолд удирдах зөвлөлийн гишүүдээс түүний оронд өөр төлөөлөгч сонгож оролцуулна.
- 13.1.2. ОУОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн Олимпын бус төрлийн олон улсын спортын холбооны гишүүн үндэсний спортын холбоо тус бүрээс нэг бие

төлөөлөгч 1 саналын эрхтэй оролцоно. Энэхүү төлөөлөгч нь холбооны ерөнхийлөгч байх ба хэрэв ерөнхийлөгч оролцох боломжгүй тохиолдолд удирдах зөвлөлийн гишүүдээс сонгогдсон төлөөлөгч байна.

- 13.1.3. МҮОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн гишүүн спортын холбоод, орон нутаг, дүүргүүдийн Олимпын зөвлөл зэрэг бусад спортын байгууллагаас санал өгөх эрх бүхий нэг бие төлөөлөгч оролцоно (энэ заалт дүрмийн 5.1.1, 13.1.1-д заасан олонх бүрдсэн тохиолдолд хэрэгжинэ). Энэхүү төлөөлөгч нь тухайн холбооны ерөнхийлөгч, спортын байгууллага, Олимпын зөвлөлийн дарга байх бөгөөд хэрэв тэд оролцох боломжгүй тохиолдолд Удирдах зөвлөлийн гишүүдээс нь сонгогдсон төлөөлөгч оролцоно.
- 13.1.4. ОУОХ-ны гишүүн болон хүндэт гишүүн Монгол Улсын иргэн 1 саналын эрхтэй оролцоно.
- 13.1.5. Энэ дүрмийн 25.1-д заасны дагуу байгуулагдсан МҮОХ-ны Тамирчдын комисс нь сүүлийн гурван Олимпын наадмын аль нэгд нь оролцсон тамирчдын төлөөлөл хоёр хүн тус бүр санал өгөх эрхтэй оролцоно.
- 13.1.6. МҮОХ-ны гишүүдийн хурлаас сонгогдсон Олимпын медальтнуудын төлөөлөл хоёр хүн тус бүр 1 саналын эрхтэй оролцоно.

#### **Арван дөрөвдүгээр зүйл. МҮОХ-ны Чуулган**

- 14.1. МҮОХ-ны Чуулганыг 4 жил тутамд Зуны Олимпын наадам зохион байгуулагдсаны дараа жилийн эхний улиралд багтаан хуралдуулна.
- 14.2. МҮОХ-ны Чуулганыг хуралдуулах хугацааг 3 сараас доошгүй хугацааны өмнө МҮОХ-ны Гишүүдийн хурлаас зарлана.
  - 14.2.1. МҮОХ-ны гишүүн байгууллага, холбоод нь МҮОХ-ны Чуулганд оролцох төлөөлөгчдийн бүртгэлийн хуудас /анкет/ болон бусад холбогдох бичиг

баримтын хамт Чуулган эхлэхээс 45 хоногийн өмнө МҮОХ-нд ирүүлсэн байна.

14.3. МҮОХ-ны Чуулганаар дараах асуудлыг хэлэлцэнэ:

- Мандатын комиссын илтгэл
- МҮОХ-ны сонгуульт хугацааны тайлан;
- МҮОХ-ны Хянан шалгах зөвлөлийн сонгуульт хугацааны тайлан;
- МҮОХ-ны Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн сонгууль;
- Хянан шалгах зөвлөлийн гишүүдийн сонгууль (дүрмийн 23 дугаар зүйлийн дагуу).

14.4. МҮОХ-ны Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн сонгуулийг дараах аргачлалаар явуулна:

14.4.1. МҮОХ-ны Чуулганы өмнөх МҮОХ-ны Гишүүдийн хурлаар Хараат бус, бие даасан сонгуулийн комиссыг байгуулна.

- Комисс нь нэр дэвшигчдийн материалыг хүлээн авахаас эхлэн сонгуулийн дүнг мэдээлэх хүртэлх сонгуулийн бүх үйл ажиллагааг хариуцна.
- Комисс нь даргыг оролцуулсан гурван хүний бүрэлдэхүүнтэй байна. Сонгуулийн комиссын гишүүдийн хэн нь ч сонгуульд нэр дэвшигч байж болохгүй бөгөөд санал өгөх эрхгүй. Гишүүд нь хараат бус, төвийг сахисан байх ба дор хаяж нэг гишүүн нь хуулийн салбарт ажилласан туршлагатай байна.

14.4.2. Хараат бус, бие даасан сонгуулийн комисс нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;

14.4.2.а. МҮОХ-ны Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчид болон Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнд нэр дэвших асуудлаар санал авах хэвлэмэл хуудсыг саналын эрхтэй төлөөлөгчдөд гуч (30)-аас доошгүй хоногийн өмнө хүргэнэ. Дээрх албан тушаалд нэр дэвших хүн нь МҮОХ-ны Чуулганд оролцох төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багтсан байна.

- 14.4.2.б. Саналын эрхтэй төлөөлөгч нь МҮОХ-ны Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлэх бол санал авах хуудсыг бөглөж, сонгууль болохоос арван таваас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн комисст ирүүлнэ.
- 14.4.2.в. МҮОХ-ны удирдах бүрэлдэхүүнд нэр дэвшигчдийн товч танилцуулгыг МҮОХ-ны Чуулган болохоос арав (10)-аас доошгүй хоногийн өмнө саналын эрхтэй гишүүдэд мэдээлнэ.  
МҮОХ-ны удирдлагын бүрэлдэхүүнд нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаас татгалзуулах саналтай бол сонгууль болохоос наймаас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн комисст мэдэгдэнэ.  
Сонгуулийн комисс энэ саналын талаар хэлэлцэн, сонгууль болохоос зургаагаас доошгүй хоногийн өмнө шийдвэрээ гарган саналын эрхтэй гишүүдэд мэдэгдэнэ. Нэр дэвшигчийн сонгогдох эрхийн талаар маргаан гарсан тохиолдолд сонгуулийн үйл ажиллагаа явагдахаас өмнө Чуулганд оруулан хэлэлцүүлж, Чуулганаас эцсийн шийдвэр гарсны дараа сонгуулийг явуулна.
- 14.4.3. Сонгуулийн санал хураалтыг нууцаар явуулна.
- 14.4.4. Сонгууль эхлэхээс өмнө Сонгуулийн комисс нь сонгуулийн үйл явц болон тодруулах шаардлагатай асуултуудад хариу өгөх үүрэгтэй.
- 14.4.5. Ерөнхийлөгчид нэр дэвшигч нийт саналын 50-аас дээш хувийг авсан тохиолдолд сонгогдсонд тооцно. Хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч 50-аас дээш хувийн санал аваагүй тохиолдолд хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг үлдээж дахин санал хурааж шийдвэрлэнэ. Дахин санал хураалтад нийт саналын 50-аас дээш хувийн санал авсан нэр дэвшигч сонгогдсонд тооцно.
- 14.4.6. МҮОХ-ны Дэд ерөнхийлөгчид олонхын саналыг авсан хоёр хүн сонгогдоно. Хамгийн олон санал авсан хүн Тэргүүн дэд ерөнхийлөгч болно. Саналын



- тоо тэнцсэн тохиолдолд дахин санал хураалт явуулан, илүү саналтай нь сонгогдох зарчмыг баримтална.
- 14.4.7. МҮОХ-ны Гүйцэтгэх зөвлөлийн болон Хянан шалгах зөвлөлийн гишүүдэд МҮОХ-ны гишүүдээс нэр дэвшүүлэн, авсан саналын тоог харгалзан тэднийг сонгоно. Саналын тоо тэнцсэн тохиолдолд дахин санал хураалт явуулж шийдвэрлэнэ.
- 14.4.8. Сонгуулийн комисс нь сонгуулийн дүнг зарлах ба сонгуультай холбогдуулан саналын эрхтэй гишүүдээс тавьсан санал хүсэлтэд Чуулган хаагдахаас өмнө хариу өгөх үүрэгтэй.
- 14.5. Чуулганаар Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн болон Хянан шалгах зөвлөлийн гишүүнийг сонгох санал хураалт явуулах тусгай журмыг Гишүүдийн хурлаар батлуулж мөрдөнө.

### **Арван тавдугаар зүйл. МҮОХ-ны Гишүүдийн хурал**

- 15.1. МҮОХ-ны Гишүүдийн хурал нь жилд нэгээс доошгүй удаа танхимаар болон онцгой нөхцөл байдал эсвэл давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд цахимаар хуралдана. Санхүүгийн тайлан гаргаж, аудит хийлгэх хугацаатай холбогдуулан хурлыг дараа оны эхний улиралд багтаан хуралдуулна.
- 15.1.1. МҮОХ-ны Чуулганыг зохион байгуулсан жил Гишүүдийн хурлыг Чуулган дууссанаас хойш хоёр сарын дотор зарлан хуралдуулж, төсөв, төлөвлөгөө, орон тоо, бүтэц бүрэлдэхүүнийг хэлэлцэн тогтооно.
- 15.2. МҮОХ-ны Гишүүдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ;
- МҮОХ-ны үйл ажиллагааны жилийн тайланг хэлэлцэн, дүгнэлт гаргах;
  - Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, зорилтыг хэлэлцэн батлах;
  - МҮОХ-ны Гишүүдийн хурлаас томилогдсон Хараат

- бус, хөндлөнгийн аудитын гаргасан өмнөх жилийн санхүүгийн тайланг сонсон, дүгнэлт гаргах;
- Тухайн жилийн төсвийг хэлэлцэн батлах;
  - Хараат бус, бие даасан сонгуулийн комиссын гишүүдийг сонгох болон МҮОХ-ны Чуулганы товыг зарлах (сонгуулийн өмнөх жилийн МҮОХ-ны Гишүүдийн хурлын үед);
  - Хянан шалгах зөвлөлтэй хамтран ажиллах Хараат бус, хөндлөнгийн аудиторыг Ерөнхийлөгчийн санал болгосны дагуу хэлэлцэж томилно. Энэ аудитор нь МҮОХ-ны жилийн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг МҮОХ-ны Гишүүдийн хуралд танилцуулна;
  - Энэхүү дүрмийн дагуу Гүйцэтгэх зөвлөл, Гишүүдийн хуралд гарсан сул орон тооны нөхөн сонгуульд нэр дэвшсэн гишүүнийг олонхын саналаар сонгоно;
  - МҮОХ-ны шинэ гишүүдийг батламжлах;
  - Гишүүнчлэлийн шаардлагыг хангаагүй гишүүнийг сонгуульт үүргээс нь чөлөөлөх эсэхийг гишүүдийн хуралд оролцож буй саналын эрхтэй гишүүдийн гуравны хоёр (2/3)-ын саналаар шийдвэрлэх (дүрмийн 6 дугаар зүйл болон 9.1.3 дахь заалтын дагуу);
  - Гишүүнийг хөөх болон түр хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэрийг Гишүүдийн хуралд оролцож буй саналын эрхтэй гишүүдийн гуравны хоёр (2/3)-ын саналаар шийдвэрлэх (дүрмийн 10 дугаар зүйлийн дагуу);
  - Гишүүнчлэлийн татварыг тогтоох;
  - МҮОХ-ны дүрмийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг Гишүүдийн хуралд оролцож буй санал өгөх эрхтэй гишүүдийн гуравны хоёр (2/3)-ын саналаар шийдвэрлэх;
  - Энэхүү дүрэм болон Олимпын Хартид нийцүүлэн гүйцэтгэх зөвлөлөөс санал болгож буй дүрмийн зүйл заалт, дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэн шийдвэрлэх;
  - МҮОХ-ноос хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэлэлцэн батлах;
  - Шаардлагатай тохиолдолд энэхүү дүрэмд тайлбар хийх (Олимпын Хартийн холбогдох заалтын дагуу);

- МҮОХ-ны дүрэмд тусгагдаагүй зүйл заалт болон энэхүү дүрэмтэй холбоотой ямар нэгэн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэхдээ Олимпын Хартийн заалтыг үндэслэл болгоно.

**Арван зургаадугаар зүйл. МҮОХ-ны Чуулган ба Гишүүдийн хурлыг зарлах, хуралдуулах үндсэн баримтлал**

- 16.1. МҮОХ-ны Чуулганыг хуралдуулах хугацааг энэ дүрмийн 14.2-т заасны дагуу Чуулган болохоос 3 сараас доошгүй хугацааны өмнө МҮОХ-ны Гишүүдийн хурлаас зарлана.
- 16.2. Гишүүдийн хурлын зарыг гуч (30)-аас доошгүй хоногийн өмнө саналын эрхтэй бүх гишүүдэд хүргэнэ.
- 16.3. Хуралд орох төлөөлөгч, гишүүдэд хурал болох өдөр, цаг, байршил хэлэлцэх асуудал болон холбогдох бусад мэдээллүүдийг хүргүүлнэ. Мөн энэ төрлийн мэдээллийг МҮОХ-ны албан ёсны цахим хуудсанд байршуулж болно. Гишүүдийн хурлын хувьд МҮОХ-ны гишүүн байгууллага, холбоод нь хуралд оролцох төлөөлөгчдийн нэрсийг Гишүүдийн хурал болохоос долоо /7/ хоногийн өмнө Ерөнхий нарийн бичигт ирүүлнэ. Чуулганы хувьд энэхүү дүрмийн 14.2.1-т заасны дагуу Чуулган болохоос дөчин тав /45/ хоногийн өмнө ирүүлсэн байна.
- 16.4. МҮОХ нь биеийн тамир, спорт хариуцсан төрийн захиргааны байгууллага, их, дээд сургууль, бусад холбогдох байгууллагаас МҮОХ-ноос тогтоосон журмын дагуу МҮОХ-ны Чуулган болон Гишүүдийн хуралд саналын эрхгүйгээр тодорхой тооны зочдыг урилгаар оролцуулж болно.
- 16.5. МҮОХ-ны Чуулган болон Гишүүдийн хурал нь шийдвэрлэх асуудлаа жагсаалтад орсон дарааллын дагуу хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлуудын жагсаалтад өөрчлөлт оруулах санал байгаа бол гишүүд нь саналаа хурал болохоос арван тав (15)-аас доошгүй хоногийн өмнө Ерөнхийлөгч болон

Ерөнхий нарийн бичгийн даргад ирүүлсэн байх ёстой. Хэрэв хэлэлцэх асуудлуудын жагсаалтад ямар нэгэн өөрчлөлт оруулсан бол, шинэчилсэн жагсаалтыг хурал болохоос арав (10)-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд хүргүүлсэн байна.

- 16.6. Шаардлагатай тохиолдолд МҮОХ-ны ээлжит бус Чуулган болон Гишүүдийн хурлыг нийт санал өгөх эрхтэй гишүүдийн 50-аас дээш хувийн эсвэл Гүйцэтгэх зөвлөл, Ерөнхийлөгчийн бичгээр гаргасан саналыг үндэслэн хугацаанаас нь өмнө зарлан хуралдуулж болно. Ээлжит бус хурал нь ээлжит хуралтай адил горимоор болно.
- 16.7. МҮОХ-ны Чуулган болон Гишүүдийн хурлыг Ерөнхийлөгч даргална. Ерөнхийлөгч эзгүй болон ажил үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд Тэргүүн дэд ерөнхийлөгч, хэрэв Тэргүүн дэд ерөнхийлөгч эзгүй болон ажил үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд Дэд ерөнхийлөгч хурлыг удирдан явуулна. Уг хурлаар сонгууль явагдах бол Гишүүдийн хурлаас сонгогдсон Хараат бус, бие даасан сонгуулийн комисс хурлыг удирдан явуулна.
- 16.8. Энэ дүрмийн бусад заалтуудад тусгайлан заагаагүй бол, МҮОХ-ны Чуулган, Гишүүдийн хурал нь нийт гишүүдийн талаас илүүгийн ирцтэйгээр, гэхдээ цугласан гишүүдийн олонх нь Олимпын наадмын хөтөлбөрт багтдаг спортын төрлийн үндэсний холбоодын төлөөлөл байх тохиолдолд хуралдана. Хэрэв дээрх нөхцөл хангагдаагүй тохиолдолд дараагийн хурлын товыг долоо хоногоор хойшлуулан зарлана. Хоёр дахь хурал хүчин төгөлдөр болох нөхцөлийг хангаж чадаагүй бол энэ хурлын нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй бүрэлдэхүүнтэй, тэдний олонх нь Олимпын наадмын хөтөлбөрт багтдаг спортын төрлийн төлөөллөөс бүрдэж байгаа тохиолдолд хуралдуулна.
- 16.9. Энэ дүрмийн бусад заалтуудад тусгайлан заагаагүй бол, МҮОХ-ны Чуулган, Гишүүдийн хурлын шийдвэрийг хуралд

оролцож буй нийт гишүүдийн талаас илүүгийн саналаар батална. Сонгуулиас бусад асуудлаар санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагч таслах саналыг өгч болно.

- 16.10. МҮОХ-ны Чуулган, Гишүүдийн хурлын олонх нь Олимпын наадмын хөтөлбөрт багтдаг спортын төрлийн олон улсын холбоодод бүртгэлтэй гишүүн спортын холбоодын төлөөлөгчид байх ёстой.
- 16.11. Олимпын наадамтай холбоотой тусгайлсан асуудлыг хэлэлцэх үед санал хураалтыг явуулахдаа зөвхөн Олимпын наадмын хөтөлбөрт багтдаг спортын төрлийн олон улсын спортын холбооны гишүүнчлэл бүхий спортын холбоодын төлөөлөгчдийн саналаар шийдвэрлэнэ.
- 16.12. Сонгууль нь энэхүү дүрэмд заасан аргачлал болон МҮОХ-ны Гишүүдийн хурлаар батлагдсан журмын дагуу явагдана.
- 16.13. Сонгууль болон гишүүдийн өөрчлөлтийн тухай хурлын тэмдэглэлийн хуулбарыг ОУОХ-нд илгээнэ. Бүх бичиг баримтуудыг МҮОХ-ны Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
- 16.14. МҮОХ-ны Чуулган, Гишүүдийн хурал болон гүйцэтгэх зөвлөлийн хурлын тэмдэглэлийг Ерөнхий нарийн бичгийн дарга хөтөлнө. Түүний эзгүйд хурал даргалагчийн томилсон Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн эсвэл Гишүүдийн хурлын гишүүн хөтөлнө. Хурлын тэмдэглэлийг хурал зохион байгуулагдсанаас гуч (30) хоногийн дотор хуралд оролцсон гишүүдэд хүргүүлнэ.

#### **Арван долоодугаар зүйл. МҮОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл**

- 17.1. МҮОХ-ны Гүйцэтгэх зөвлөл нь МҮОХ-ны гүйцэтгэх байгууллага бөгөөд Гишүүдийн хурлын хоорондох үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

17.2. Гүйцэтгэх зөвлөл нь МҮОХ-ны Чуулганаас сонгогдсон дараах 9 гишүүнээс бүрдэнэ:

- Ерөнхийлөгч;
  - Дэд ерөнхийлөгч 2 хүн;
  - Бусад 6 гишүүн;
- Дээрхээс гадна ОУОХ-ны гишүүнийг (албан тушаалаараа) болон Тамирчдын комиссын төлөөлөл 1 хүнийг заавал оруулсан байна.

17.3. Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн 2-оос доошгүй нь эмэгтэйчүүдийн төлөөлөл байна. Эсрэг хүйсийн төлөөллийг 30 хувьд хүргэх талаар хүчин чармайлт гаргана.

17.4. ОУОХ-ны хүндэт гишүүн нь Гүйцэтгэх зөвлөлийн хүндэт гишүүн байх бөгөөд санал хураалтаас бусад тохиолдолд Гүйцэтгэх зөвлөлийн гишүүний эрх, үүргийг эдэлнэ.

17.5. Гүйцэтгэх зөвлөлийн гишүүд нь энэхүү дүрмийн сонгуулийн журмын дагуу Чуулганаас 4 жилийн хугацаатай сонгогдоно. Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн дахин сонгогдох боломжтой. Гэвч дараах тохиолдолд шинээр сонгогдох болон дахин сонгогдох боломжгүй;

- Гишүүн 75 нас хүрсэн;
- Гишүүн 4 жилийн хугацаатай 2 дараалан Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнээр ажилласан;

Энэ заалтыг дүрэмд шинээр нэмэлт, өөрчлөлт орсон өдрөөс эхлэн тооцох бөгөөд буцаан хэрэглэхгүй. Эргэлзээтэй байдал үүсгэхээс зайлсхийхийн тулд хоёр (2) дараалсан гэх нөхцөлийн хязгаарлалт нь зөвхөн Гүйцэтгэх зөвлөлд МҮОХ-ны дүрмийн 17.2-р зүйлийн дагуу сонгогдсон албан тушаалтнуудад хамаарах бөгөөд Олимпын Хартийн дагуу ОУОХ-ны гишүүний албан тушаалаараа Гүйцэтгэх зөвлөлд орсон гишүүнд хамаарахгүй.

17.6. Олимпын Хартийн дагуу, Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийг болон тэднийг сонгох саналын олонхыг Олимпын наадмын

хөтөлбөрт багтдаг спортын төрлийн олон улсын холбооны гишүүн спортын холбоодын төлөөлөгчид бүрдүүлэх зарчим хадгалагдана.

### **Арван наймдугаар зүйл. МҮОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл дэх сул орон тоо**

18.1. Гүйцэтгэх Зөвлөлд дараах тохиолдлуудад сул орон тоо үүснэ.

- 18.1.1. Нас барах;
- 18.1.2. Өөрийн хүсэлтээр гишүүнээс чөлөөлөгдөх (бичгээр);
- 18.1.3. Гишүүнчлэлээс чөлөөлөх болон хасах (Тухайн гишүүнд тайлбар хийх хангалттай боломж олгон түүнийг сонссоны дараа гишүүдийн хуралд оролцож буй гишүүдийн гуравны хоёр (2/3)-оос доошгүй саналаар гишүүнээс хасна.

18.2. Гүйцэтгэх зөвлөл дэх сул гишүүний орон тоог дараагийн Гишүүдийн хурлаар сонгоно. (Сонгууль явуулах журмын дагуу)

### **Арван есдүгээр зүйл. МҮОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн эрх, үүрэг**

19.1. МҮОХ-ны Гүйцэтгэх зөвлөл нь дараах эрх, үүрэгтэй байна.

- 19.1.1. Гишүүдийн хурлаар баталсан стратеги төлөвлөгөө, төсөв болон ерөнхий бодлогын хүрээнд МҮОХ-г дүрэмд нийцүүлэн удирдан зохион байгуулах бөгөөд МҮОХ-ны Чуулган, Гишүүдийн хуралд үйл ажиллагаагаа тайлагнана.
- 19.1.2. МҮОХ-ны стратеги төлөвлөгөө, ерөнхий бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг тодорхойлж, батлах саналаа Гишүүдийн хуралд оруулахад бэлтгэх;
- 19.1.3. МҮОХ-ны Чуулган, Гишүүдийн хурлаас гарсан аливаа шийдвэр, тогтоолыг хэрэгжүүлэх;
- 19.1.4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, жилийн төсөв, төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж, Гишүүдийн хуралд оруулахад бэлтгэх;
- 19.1.5. Чуулганд оруулах дөрвөн жилийн ажлын тайланг хэлэлцэн бэлтгэх;

- 19.1.6. МҮОХ-ны өмч болон мөнгөн хөрөнгийг Гишүүдийн хурлаар баталсны дагуу захиран зарцуулах;
- 19.1.7. Спортын холбоодоос ирүүлсэн саналыг үндэслэн, ОУОХ-ны ивээл дор зохиогддог бүс, тив, дэлхий, Олимпын наадамд баг тамирчдыг сонгон шалгаруулж, зохион байгуулан оролцуулах;
- 19.1.8. Шаардлагатай тохиолдолд спортын холбоод, гишүүдийг мэргэжлийн удирдлагаар ханган дэмжлэг үзүүлэх асуудлыг хэлэлцэх;
- 19.1.9. МҮОХ-ны үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх зорилгоор гишүүдээс бүрдсэн комиссууд болон ажлын хэсэг байгуулж, тэдгээрийн ажлын чиг удирдамжийг батлан мөрдүүлэх;
- 19.1.10. Гишүүнээр элсэх хүсэлтийг хэлэлцэн, Гишүүдийн хуралд оруулах эсэх асуудлыг шийдвэрлэх;
- 19.1.11. Шаардлагатай гэж үзвэл МҮОХ-ны дүрмийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулан гишүүдийн хуралд хэлэлцүүлэх;
- 19.1.12. МҮОХ-ны Чуулган, Гишүүдийн хурлын шийдвэр болон дүрмийн заалтыг зөрчсөн аливаа үйлдэлд сахилгын шийтгэл оногдуулах;
- 19.1.13. МҮОХ-ны Ерөнхийлөгчийн санал болгосны дагуу Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх болон төсөвт нийцүүлэн МҮОХ-ны ажлын албаны орон тоо, бүтцийг хэлэлцэж, дотоод журмуудыг батлах;
- 19.1.14. МҮОХ-ны Чуулган, Гишүүдийн хурлаас гаргасан шийдвэр болон дүрэмд заасан бусад үүргийг гүйцэтгэх.

### **Хорьдугаар зүйл. Гүйцэтгэх зөвлөлийн хурал**

- 20.1. Гүйцэтгэх зөвлөл нь гурван сар тутамд танхимаар болон онцгой нөхцөл байдал эсвэл давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд цахимаар хуралдана. Шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал хийж болно.



- 20.2. Ерөнхийлөгч эсвэл Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн гуравны нэг нь бичгээр хүсэлт ирүүлсэн тохиолдолд нэмэлт хурлыг зарлан хуралдуулна.
- 20.3. Ерөнхийлөгч Гүйцэтгэх зөвлөлийн хурлыг даргална. Ерөнхийлөгч эзгүй болон боломжгүй тохиолдолд Тэргүүн дэд ерөнхийлөгч, хэрэв Тэргүүн дэд ерөнхийлөгч эзгүй болон боломжгүй тохиолдолд Дэд ерөнхийлөгч гэсэн дарааллаар хурлыг удирдана.
- 20.4. Гүйцэтгэх зөвлөлийн хурлыг долоо (7)-гоос доошгүй хоногийн өмнө гишүүдэд зарлана. Гишүүдэд хурал болох өдөр, цаг, байршил зэрэг мэдээллүүд, хурлаар хэлэлцэх асуудлуудыг шаардлагатай бичиг баримтуудын хамтаар хүргүүлнэ.
- 20.5. Гүйцэтгэх зөвлөлийн хурал нь нийт гишүүдийн талаас илүү нь ирсэн тохиолдолд хүчин төгөлдөр байна.
- 20.6. Ирсэн гишүүдийн талаас илүү нь саналаа өгсөн тохиолдолд шийдвэр хүчинтэйд тооцогдоно.
- 20.7. Санал тэнцсэн тохиолдолд, хурал даргалагч таслах саналыг өгнө.
- 20.8. Ерөнхий нарийн бичгийн дарга эсвэл түүний эзгүйд хурал даргалагчийн томилсон Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн нь хурлын тэмдэглэлийг хөтлөх үүрэгтэй. Хурлын тэмдэглэлийг хурал болсноос хойш долоо хоногийн дотор Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдэд хүргэсэн байна.
- 20.9. Тухайн хэлэлцэж байгаа асуудал Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнтэй сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохоор байвал энэ тухайгаа өөрөө тайлбарлаж хэлэлцүүлэг, санал хураалтад оролцохгүй.

## **Хорин нэгдүгээр зүйл. МҮОХ-ны Ерөнхийлөгч**

- 21.1. МҮОХ-ны Ерөнхийлөгч нь МҮОХ-г эх орондоо болон олон улсын тавцанд төлөөлнө.
- 21.2. МҮОХ-ны Ерөнхийлөгч орон тооны байх ба бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байна. Дахин нэг удаа сонгогдож болно.
- 21.3. МҮОХ-ны Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд МҮОХ-г төлөөлж шийдвэр гарган, гарын үсэг зурна.
- 21.4. МҮОХ-ны Ерөнхийлөгч нь МҮОХ-ны өмч, мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэр гаргаж, Ерөнхий нарийн бичгийн дарга санхүүгийн баримтад гарын үсэг зурна. Гүйцэтгэх зөвлөлд санхүүгийн тайланг танилцуулна.
- 21.5. МҮОХ-ны Ерөнхийлөгч нь Чуулган, Гишүүдийн хурал, Гүйцэтгэх зөвлөлийн хурлыг даргалан хуралдуулна. Эдгээр хурлын тэмдэглэлтэй танилцан, гарын үсэг зурж баталгаажуулна.
- 21.6. МҮОХ-ны Ерөнхийлөгч нь МҮОХ-ны үйл ажиллагааг Олимпын Харти болон энэхүү дүрэмд нийцүүлэн явуулах шаардлагыг ханган хэрэгжүүлж, Олимпын зарчим, ёс зүйг Олимпын хөдөлгөөнөөр дамжуулан түгээн дэлгэрүүлнэ.
- 21.7. МҮОХ-ны Ерөнхийлөгч нь эх орон, олон улсын тавцанд МҮОХ-той харилцагч байгууллагууд, оролцогч талуудын хоорондын найрсаг харилцааг бэхжүүлэн ажиллана.
- 21.8. МҮОХ-ны Ерөнхийлөгч нь Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллуулах хүнийг Гүйцэтгэх зөвлөлд томилуулах санал оруулж, батлуулна.
- 21.9. МҮОХ-ны Ерөнхийлөгч нь МҮОХ-ны Чуулган, Гишүүдийн хурал, Гүйцэтгэх зөвлөлөөс хүлээлгэсэн үүргийг цаг тухайд нь гүйцэтгэн ажиллана.

- 21.10. Хэрэв Ерөнхийлөгч тодорхой хугацаанд албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Тэргүүн дэд ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч боломжгүй тохиолдолд Дэд ерөнхийлөгч нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд дүрмийн 18 дугаар зүйлийг баримтална.
- 21.11. МҮОХ-ны Ерөнхийлөгч нь МҮОХ-ны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдана.

### **Хорин хоёрдугаар зүйл. Ерөнхий нарийн бичгийн дарга**

- 22.1. Ерөнхийлөгчийн санал болгосноор Ерөнхий нарийн бичгийн даргыг Гүйцэтгэх зөвлөлийн хурлаас томилох буюу чөлөөлнө.
- 22.2. Ерөнхий нарийн бичгийн дарга нь МҮОХ-ны ажлын албаны үйл ажиллагааг зохион байгуулах орон тооны албан тушаалтан байна.
- 22.3. Ерөнхий нарийн бичгийн дарга нь МҮОХ-ны ажлын албыг удирдаж, Чуулган, Гишүүдийн хурал, Гүйцэтгэх зөвлөл, Ерөнхийлөгчөөс өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллана.
- 22.4. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Ерөнхийлөгч, Гүйцэтгэх зөвлөл, Хянан шалгах зөвлөлөөс өгсөн үүрэг чиглэлийн дагуу, тэдний удирдлага дор дараах ажлуудыг зохих журамд нийцүүлэн ханган ажиллана;
- МҮОХ-ны санхүүгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эсэх;
  - Байгууллагын эд материал, мөнгөн хөрөнгийн бүртгэл тооцоо зохих журмын дагуу хийгдэж байгаа эсэх;
  - Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт шаардлага хангаж байгаа эсэх;
  - МҮОХ-ны санхүүд Хараат бус, хөндлөнгийн аудитораар шалгалт хийлгэх ажлыг зохион байгуулах;

- Хараат бус, хөндлөнгийн аудитор шалгалтын дүнг Гишүүдийн хуралд танилцуулж байгаа эсэхэд хяналт тавих;
- 22.5. МҮОХ-ны Чуулган, Гишүүдийн хурал, Гүйцэтгэх зөвлөлийн хуралд бэлтгэх, хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцна.
- 22.6. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Чуулган, Гишүүдийн хурал, Гүйцэтгэх зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтлөн хадгална.
- 22.7. Ерөнхий нарийн бичгийн дарга нь гишүүдийн талаар бүртгэл мэдээллийг хөтөлж, хадгалах үүрэгтэй.
- 22.8. Ерөнхий нарийн бичгийн дарга нь комисс болон ажлын хэсгийн үйл ажиллагааг зохицуулна.
- 22.9. Ерөнхий нарийн бичгийн дарга нь ОУОХ-ны Эв санааны нэгдлээс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд МҮОХ-ны оролцоог хангаж, зохион байгуулан ажиллана.
- 22.10. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Чуулган, Гишүүдийн хурал, Гүйцэтгэх зөвлөл, Ерөнхийлөгчөөс үүрэг болгосон үйл ажиллагааг цаг тухайд нь хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **Хорин гуравдугаар зүйл. Хянан шалгах зөвлөл**

- 23.1. Хянан шалгах зөвлөлийг (цаашид “ХШЗ” гэж товчилно) Чуулганы гишүүдээс нэр дэвшүүлж дөрвөн жилийн хугацаатай сонгоно.
- 23.2. ХШЗ-д нэр дэвшигчид ХШЗ-ийн үйл ажиллагааг хариуцлагатайгаар явуулах хууль зүй болон санхүүгийн мэдлэг чадвартай байна.
- 23.3. ХШЗ нь зөвлөлийн даргыг оролцуулаад таван хүний бүрэлдэхүүнтэй байна.

- 23.4. ХШЗ нь анхны хурлаа хийж, бүрэлдэхүүнээсээ дарга, нарийн бичгийн даргаа сонгоно.
- 23.5. ХШЗ-ийн сул орон тоог дараагийн Гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ.
- 23.6. ХШЗ дараах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.  
Үүнд:
- МҮОХ-ны дүрмийн биелэлт;
  - Ерөнхийлөгчийн болон Гүйцэтгэх зөвлөлийн шийдвэр нь Олимпын Харти, МҮОХ-ны дүрэм, журам, бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх;
  - МҮОХ-ны ажлын алба, харьяа байгууллага, архив, бичиг хэрэг, санхүүгийн үйл ажиллагаа;
  - Гишүүн спорт холбоодын үйл ажиллагаа;
  - МҮОХ-ны санхүүгийн үйл ажиллагаанд зөвлөмж өгөх;
- 23.7. ХШЗ нь аудитын тайланг Чуулган, Гишүүдийн хурал болон Гүйцэтгэх зөвлөлд танилцуулна.

#### **Хорин дөрөвдүгээр зүйл. Комисс ба ажлын хэсгүүд**

- 24.1. МҮОХ-ны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд МҮОХ-ны гишүүдээс бүрдсэн комисс болон ажлын хэсгийг Гүйцэтгэх зөвлөлийн шийдвэрээр байгуулж болно.
- 24.2. Гүйцэтгэх зөвлөл нь тэдгээр комисс болон ажлын хэсгийн бүтэц, үйл ажиллагааны чиглэл, үүргийг тодорхойлно.

#### **Хорин тавдугаар зүйл. МҮОХ-ны Тамирчдын комисс**

- 25.1. ОУОХ-ноос баталсан Үндэсний Олимпын Хороодын Тамирчдын комиссын журмын дагуу байгуулагдсан МҮОХ-ны Тамирчдын комисс нь энэхүү дүрмийн хавсралт 1-д заасны дагуу үйл ажиллагаа явуулна.

### **Хорин зургаадугаар зүйл. Төр, засгийн байгууллагатай харилцах**

- 26.1. МҮОХ нь биеийн тамир, спортыг хөгжүүлэх асуудлаар санал боловсруулж, төр, засгийн байгууллагад өргөн барих, шийдвэрлэхэд хамтран ажиллах;
- 26.2. Монгол Улсын Засгийн газраас Биеийн тамир, спортыг хөгжүүлэх төр, засгийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр эрхлэн гүйцэтгэх, шаардагдах хөрөнгийг төрөөс авч, зарцуулалтыг Засгийн газарт тайлагнана.
- 26.3. Биеийн тамир, спортын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлж, үр дүнг сургалт дасгалжуулалтад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

### **Хорин долоодугаар зүйл. МҮОХ-ны Олимпын зөвлөл**

- 27.1. МҮОХ нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн нэгжийн зохион байгуулалтын дагуу өөрийн салбар байгууллага болох Олимпын зөвлөлийг байгуулан ажиллуулна.
- 27.2. Олимпын зөвлөл нь тухайн орон нутаг, хот, дүүрэгт МҮОХ-ны бодлого, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг өөрийн дүрмийн дагуу эрхлэн гүйцэтгэнэ.
- 27.3. Олимпын зөвлөл нь энэхүү дүрмийн дагуу МҮОХ-ны гишүүн байна. Олимпын зөвлөлийн дүрмийг МҮОХ-ны Гүйцэтгэх зөвлөлийн хурлаар батална.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### ХӨРӨНГӨ, САНХҮҮ

#### **Хорин наймдугаар зүйл. МҮОХ-ны хөрөнгө, санхүү**

28.1. МҮОХ зорилгоо хэрэгжүүлэхийн тулд Олимпын Хартид нийцүүлэн санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлнэ.

28.2. МҮОХ-ны хөрөнгө, санхүү дараах эх үүсвэрүүдээс бүрдэнэ.  
Үүнд:

- ОУОХ, гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсээс МҮОХ-нд хандивласан техник, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хэрэглэл материал, эд зүйлс, үндэсний болон гадаад валют;
- Олимпын хөдөлгөөнд зориулж өөрийн хөрөнгөөр бий болгосон барилга байгууламж, музей, номын сан, спортын үйл ажиллагаанд зориулж хувь хүн, хуулийн этгээдээс хандивласан хөрөнгө оруулалт, барилга байгууламж;
- Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон спортын маркетинг, мөнгөн хонжворт сугалаа гэх мэт аж ахуйн үйл ажиллагаанаас орсон орлого;
- Үйл ажиллагааны явцад бүрдсэн архивын материал, олон улсын спортын байгууллагын баримт бичиг;
- МҮОХ-ны гишүүн байгууллагын элсэлтийн ба жилийн татвар;
- Бусад орлого;

28.3. МҮОХ-ны хөрөнгө, санхүүг Олимпын үзэл санаа, спортыг хөгжүүлэх үйл ажиллагаанд зориулна.

28.4. Олимпын Эв санааны нэгдлээс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдээр дамжуулан хуваарилагдсан хөрөнгө, төсвийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна.

28.5. МҮОХ нь өөрийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй. МҮОХ-ны орлогоос ногдол ашиг

хуваарилах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг төлөхийг хориглоно.

28.6. Төрийн бус байгууллагын тухай хууль болон Олимпын Хартид нийцүүлэн МҮОХ-ны харьяалалд спорт сугалааны газар /sport lotto/ ба спортын барааны дэлгүүр зэргийг ажиллуулж болно.



## ТАВДУГААР БҮЛЭГ

### МҮОХ-НЫ БЭЛГЭДЭЛ

#### **Хорин есдүгээр зүйл. Бэлгэдэл**

- 29.1. МҮОХ-ны бэлгэдэл нь Олимпын таван цагаригийн дээд талд гал, нар, сарыг дүрслэн дээдэлсэн байх бөгөөд дор нь “Монголын Үндэсний Олимпын Хороо” гэсэн бичээстэй байна. Зурган дүрслэлийг энэхүү дүрмийн Хавсралт 3-аар хавсаргав.
- 29.2. МҮОХ-ны туг нь 1:2 хэмжээний цагаан дэвсгэр дээр МҮОХ-ны бэлгэдлийг байрлуулсан зохиомжтой байна.
- 29.3. МҮОХ үйл ажиллагаандаа, тухайлбал Олимпын наадамд албан хэрэгцээнд сонгосон туг, бэлгэдлийг ОУОХ-гоор зөвшөөрүүлнэ. Олимпын Хартийн дагуу МҮОХ-ны бэлгэдлийг хэрэглэх журмыг Гүйцэтгэх зөвлөлийн хурлаар батлан мөрдөнө.
- 29.4. МҮОХ нь МҮОХ-ны бэлгэдэл бүхий албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг хэрэглэнэ.
- 29.5. МҮОХ нь өөрийн хэвлэл, шагналтай байна.

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ

### МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

#### Гучдугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

- 30.1. Маргаантай асуудлыг МҮОХ-ны дүрэм, Олимпын Харти, Азийн Олимпын зөвлөлийн дүрэм (Азийн Олимпын зөвлөл эсвэл Азийн наадамтай холбоотой үүссэн асуудлуудын хувьд), Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 30.2. МҮОХ болон гишүүдийн хооронд спортын үйл ажиллагаатай холбоотой эсвэл байгууллага хоорондын маргаан гарсан тохиолдолд МҮОХ-нь Хянан шалгах зөвлөл эсвэл Гүйцэтгэх зөвлөлд хандан шийдвэрлүүлнэ. Хэрэв спортын холбоотой хамааралтай асуудал бол олон улсын холбоотой хамтран хэлэлцэж, зөвлөлдсөний үндсэн дээр шийдвэрлүүлнэ. Шүүхтэй хамааралгүй асуудлыг Гүйцэтгэх зөвлөл болон Гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ. Гишүүдийн хурал, Гүйцэтгэх зөвлөл нь эцсийн шийдвэрийг гаргаж болох бөгөөд эсвэл маргааныг шийдвэрлэх зорилгоор хараат бус эвлэрүүлэн зуучлах болон арбитрын комиссыг байгуулж болно.
- 30.3. Гишүүдийн хурлаас гаргасан эсвэл Гишүүдийн хурлаас байгуулсан хараат бус эвлэрүүлэх, зуучлах болон арбитрын комиссын эцсийн шийдвэрийг маргаантай гэж үзсэн тохиолдолд Швейцарын Лозанн хотод байрлах Спортын арбитрын шүүхэд давж заалдаж болно. Энэ шүүх спортын шүүхийн дүрмийн дагуу асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ. Аливаа шийдвэр гарснаас хорин нэгэн өдрийн (21) дотор давж заалдах эрхтэй.

## ДОЛООДУГААР БҮЛЭГ

### БУСАД ЗҮЙЛ

#### **Гучин нэгдүгээр зүйл. Татан буулгах**

- 31.1. МҮОХ-г Чуулган, Гишүүдийн хурлаас саналын эрхтэй гишүүдийн гуравны хоёр (2/3)-ын ирцтэйгээр, саналын эрхтэй гишүүдийн гуравны хоёр (2/3)-оос доошгүй саналаар татан буулгаж болно.
- 31.2. Татан буугдсан тохиолдолд, МҮОХ нь хуулийн дагуу үүссэн өр төлбөрийг бүрэн барагдуулж, үлдсэн эд хөрөнгийг ОУОХ-той зөвшилцсөний үндсэн дээр Чуулган, Гишүүдийн хурлаас шийдвэрлэсний дагуу түүний хууль ёсны залгамжлагчид, эсвэл байхгүй бол ижил төстэй зорилго бүхий байгууллагад шилжүүлнэ.

#### **Гучин хоёрдугаар зүйл. МҮОХ-ны дүрэмд өөрчлөлт оруулах болон Олимпын Хартийг баримтлах**

- 32.1. МҮОХ-ны дүрэм нь Олимпын Хартид ямагт нийцэж, түүний утга санааг тод тусгасан байх ёстой. МҮОХ-ны дүрмийн утга санаа болон тайлбарын тухайд эргэлзээтэй зүйл гарах, мөн энэ дүрэм нь Олимпын Хартиас зөрөх тохиолдолд Олимпын Хартийг мөрдөнө.
- 32.2. Гишүүдийн хуралд оролцож буй саналын эрхтэй гишүүдийн гуравны хоёр (2/3)-оос доошгүй саналаар дүрэмд өөрчлөлт оруулж, батална.
- 32.3. МҮОХ-ны дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг ОУОХ-гоор заавал батлуулна.
- 32.4. Одоогийн Дүрэм нь МҮОХ-ны Гишүүдийн хурлаар батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр болох бөгөөд энэ дүрэм батлагдсанаар МҮОХ-ны өмнөх бүх дүрмийг хүчингүйд тооцно.

## МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛИМПЫН ХОРОО

## ХАВСРАЛТ 1

### МҮОХ-НЫ ТАМИРЧДЫН КОМИССЫН УДИРДАМЖ

#### Нэг. Эрхэм зорилго

МҮОХ-ны Тамирчдын комисс (цаашид “Комисс” гэж товчилно)-ын эрхэм зорилго нь Монголын тамирчдын үзэл санааг илэрхийлж, МҮОХ-нд тэдний дуу хоолойг хүргэхэд оршино.

#### Хоёр. Зорилт

Комиссын зорилтууд нь:

- а. Тамирчдад тулгарч буй асуудлуудыг хэлэлцэн, МҮОХ-д зөвлөмж хүргүүлэх;
- б. Тэмцээн, уралдааны талбарт болон нийгмийн амьдрал дахь цэвэр шударга тамирчдыг дэмжих, хамгаалах, үүнд хамаарах төсөл хөтөлбөрт идэвхтэй оролцох;
- в. Тамирчдын эрх ашгийг төлөөлөн, холбогдох зөвлөмжийг гаргах, Олон улсын спортын арбитрын зөвлөлд арбитрчийг томилох;
- г. 2018 оны 10 дугаар сард Буэнос Айрэс хотноо болсон ОУОХ-ны 133 дугаар хуралдаанаар Олимпын хөдөлгөөний нэрийн өмнөөс танилцуулж, баталсан “Тамирчдын эрх, үүрэг хариуцлагын тухай тунхаглал”-ыг МҮОХ-ны Гүйцэтгэх зөвлөлтэй хамтран баталж, МҮОХ-ны бодлого, журамд оруулах. Ялангуяа комисс нь МҮОХ-той хамтран эдгээр эрх, үүрэгтэй холбоотойгоор үр дүнтэй арга механизмыг боловсруулж, тамирчдыг эдгээр механизмыг ашиглахад нь дэмжлэг үзүүлэх;
- д. ОУОХ-ны болон АОЗ-ийн Тамирчдын комисстой байнгын холбоотой ажиллах;

#### Гурав. Комиссын бүтэц

- а. Комисс нь хамгийн багадаа Монгол Улсын иргэн тав (5)-н гишүүнтэй байна. Гишүүд нь хамгийн багадаа 16 настай байх ёстой бөгөөд Дэлхийн допингийн эсрэг дүрмийг зөрчиж байгаагүй байна.

- б. Комиссын гишүүдийн дийлэнх олонх нь нэр дэвших/сонгогдох хугацаандаа эсвэл сүүлийн 8 жилийн хугацаанд Олимпын хөтөлбөрт багтсан спорт төрлөөр үндэсний хэмжээнд өрсөлддөг тамирчид байна.
- в. Комисс нь сүүлийн гурван олимпын наадмын дор хаяж нэгт нь оролцсон гурав (3)-аас доошгүй тамирчнаас бүрдэнэ.
- г. Комисст хүйсийн төлөөлөл тэнцвэртэй хангагдсан байх ёстой.
- д. Комиссын гишүүдийн дийлэнх нь тамирчдаас сонгогдсон байна.
- е. Комиссын даргыг гишүүдийн саналаар сонгосон байх ёстой.
- ё. Гишүүдийн сонгуульт ажлын хугацаа дөрвөн жил байна. Хугацаа сунгагдаж болно.
- ж. Дараах холбогдох албан тушаалтнууд Комиссын саналын эрхтэй гишүүд байна:
  - ОУОХ-ны Тамирчдын комисс дахь Монгол гишүүд;
  - Азийн Олимпын Зөвлөлийн Тамирчдын комисс дахь Монгол гишүүд.

### **Дөрөв. МҮОХ-д комиссыг төлөөлөх**

Комиссыг төлөөлөн МҮОХ-ны Чуулган/Гишүүдийн хуралд хоёр гишүүн саналын эрхтэйгээр оролцох бөгөөд сүүлийн гурван Олимпын наадмын аль нэгт нь оролцож байсан тамирчдаас сонгогдсон байна.

Комиссыг төлөөлөн МҮОХ-ны Гүйцэтгэх зөвлөлд нэг гишүүн саналын эрхтэйгээр багтах бөгөөд МҮОХ-ны Чуулган/Гишүүдийн хурлаар батламжилна. Энэ төлөөлөгчийг комиссоос сүүлийн гурван Олимпын наадмын аль нэгт нь оролцож байсан тамирчдаас санал хураалтаар сонгосон байна.

### **Тав. Комиссын хурал**

- а. Комиссын хурал нь жилд нэгээс доошгүй удаа явагдана.
- б. МҮОХ нь комиссын гишүүдийн хурлыг зохион байгуулах ажлыг хариуцна.

## ХАВСРАЛТ 2

### МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛИМПЫН ХОРООНЫ ЧУУЛГАНААР ЕРӨНХИЙЛӨГЧ, ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ, ГҮЙЦЭТГЭХ ЗӨВЛӨЛ, ХЯНАН ШАЛГАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ, САНАЛ ХУРААЛТ ЯВУУЛАХ ЖУРАМ

2016 оны 9 дүгээр  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

#### Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь МҮОХ-ны Дүрмийн 14.4, 14.5 дугаар заалтын дагуу Монголын Үндэсний Олимпын Хорооны Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн, Хянан шалгах зөвлөлийн гишүүнийг сонгох үйл ажиллагааг явуулахад оршино.
- 1.2. МҮОХ-ны Дүрэм батлагдсанаар энэхүү журам хүчин төгөлдөр үйлчилнэ.

#### Хоёр.Санал хураах үйл ажиллагаа


- 2.1. МҮОХ-ны удирдлагад нэр дэвшигчдээс асууж танилцаж, тэдний хөтөлбөрийг сонсоно.
- 2.2. Сонгуулийн санал хураалтын хуудас тоолох төлөөлөгчдийг сонгож, ажилд нь оруулна.
- 2.3. Саналын хуудсанд нэр дэвшигчдийг үсгийн дарааллаар бичнэ.
- 2.4. Саналын хуудсыг баталгаажуулж, гэмтэлгүй хуудсанд Сонгуулийн комисс тэмдэг дарж баталгаажуулна.
- 2.5. Сонгуулийн комисс нь санал хураалтын хайрцгийг гишүүдэд үзүүлж давхар лацадна.

- 2.6. Гишүүдийг нэрсээр дуудаж, мандатыг тулгаж саналыг өгүүлнэ.
- 2.7. Төлөөлөгчид саналаа өгөхдөө сонгох хүнийхээ нэрийн өмнөх дугаарыг дугуйлж тэмдэглээд, саналын хуудсыг нэг нугалж хайрцагт хийнэ.
- 2.8. Сонгуулийн хуудсанд ямар нэг тэмдэглэгээ хийхийг хориглоно. Тэмдэглэгээ хийсэн, гэмтээсэн, давхар санал дугуйлсан болон хоосон хуудсыг хүчингүйд тооцно.
- 2.9. Санал хураалтын үед утсаар ярихыг хориглоно. Гар утсаа сонгогчид унтраасан байна.
- 2.10. Сонгуулийн комисс Чуулганы танхимд гишүүдийн өмнө саналын хуудсыг тоолно. Саналын тоо, хувийг хүчинтэй хуудсаар тооцно.
- 2.11 Бусдыг төлөөлж санал өгөхийг хориглоно.
- 2.12. Санал авч дууссанаа сонгуулийн комисс зарлана. Зарласнаас хойш саналын хуудас хүлээн авахгүй.

### **Гурав. Сонгууль явуулахад тавигдах шаардлага**

- 3.1. Сонгуулийн санал хураалтын хайрцаг нь гаднаасаа нэвт харагддаг материалаар хийгдсэн байна.
- 3.2. Санал хураалтыг Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Гүйцэтгэх зөвлөлийн гишүүд, Хянан шалгах зөвлөлийн гишүүдийг сонгох дарааллаар явуулна.

### ХАВСРАЛТ 3



Монголын Үндэсний Олимпын Хороо